

## ЭРДЭМТНИЙ ОЙ

**МИХАИЛ ИОСИФОВИЧ СЛАДКОВСКИЙН 75 НАСНЫ ОЙД**

**ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, Хятадыг судлагч, нэрт эрдэмтэн** Михаил Иосифович Сладковский 1906 оны арван нэгдүгээр сарын 21-нд төрж, Зөвлөлтийн Алс Дорнодын Улсын Их Сургуулийг 1950 онд төгсчээ.

М. И. Сладковский их сургууль төгсөөд гадаад худалдааны байгууллагад 35 жил хариуцлагатай ажил (ЗСБНХУ-ын Гадаад Худалдааны Яамны Алс Дорнодын секторын эрхлэгч, Газрын дарга, БНХАУ-д ЗХУ-ын Худалдааны төлөөлөгч, Гадаад Худалдааны Яамны коллегийн гишүүн) хийж байжээ.

Зөвлөлт эх орны дайны жилүүдэд гадаад худалдааны шугамаар манай оронд удтал ажиллажээ. Манжуурыг чөлөөлсний дараа 1945 оны есдүгээр сараас 1946 оны дөрөвдүгээр сард М.И. Сладковский ЗХУ-ын маршал Малиновскийн командалсан зөвлөлтийн цэргийн группт эдийн засгийн зөвлөхөөр ажиллаж байжээ.

М. И. Сладковский 1950-1961 онд Москвагийн Дорно дахины Судлалын Хүрээлэнд багшлахын зэрэгцээ, мөн ЗСБНХУ-ын Гадаад Явдлын Яамны Олон Улсын Харилцааны Москвагийн Дээд Сургуульд Хятадын эдийн засгийн асуудлаар лекц уншдаг байв. М.И. Сладковский Хятад болон Алс Дорнодын бусад орны эдийн засгийг судлахын зэрэгцээ ЗСБНХУ-ын Гадаад Худалдааны Яамны дэргэдэх Нийтийн зах зээлийн эрдэм шинжилгээний институт болон ЗСБНХУ-ын ШУА-ийн Хятад судлалын эрдэм шинжилгээний ажилд идэвхтэй оролцдог байжээ.

1959 онд М. И. Сладковский эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалж, 1961 онд профессор болжээ.

М. И. Сладковский 1965 онд ЗХУКН-ын Төв Хорооны хэлтсийн орлогч эрхлэгч, 1966 оны эцсээр ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын институтын захирлаар томилогдон одоо хүртэл ажиллаж байна. Түүний эрдэм шинжилгээний амжилт бүтээлийг өндөр үнэлж 1972 онд ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгожээ.

М. И. Сладковский ЗХУ-ын шинжлэх ухааны салбарт зохион байгуулах болон эрдэм шинжилгээний, ялангуяа

Дорно дахин, хягадын судлалын ажилд авъяас билгээ бүрэн зориулж иржээ. Түүний удирдлагаар ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын Хүрээлэн хятадын түүх, гадаад, дотоод бодлого, үзэл суртал, соёл, эдийн засгийн салбарын эрдэм шинжилгээний өргөн их цар хүрээтэй ажил зохиож богино хугацаанд ихээхэн амжилт олжээ. Тус Хүрээлэн сүүлийн 15 жилд эрдэм шинжилгээний 300 гаруй ганц сэдэвт зохиол, эмхтгэл олон мянган өгүүлэл хэвлэн нийтэлж ах дүү социалист орнуудтай, тухайлбал БНМАУ-тай хятадын судлалын судалгаа шинжилгээний ажлыг харилцан зохицуулах эрдэм шинжилгээний томоохон төв болов. Хүрээлэнгийн эрдэмтэд монголын эрдэмтэдтэй тасралтгүй нягт хамтран ажиллаж ирлээ. Түүнчлэн капиталист болон хөгжиж байгаа орнуудын шинжлэх ухааны төвүүдтэй харилцаа тогтоож Европын хятад судлалын холбооны ажилд байнга оролцдог болжээ.

Алс Дорнодын Хүрээлэнд ах дүү социалист орнууд, тухайлбал БНМАУ хятад судлалаар өндөр мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг юм. Өнгөрсөн жилүүдэд энэ Хүрээлэнгийн дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөс 100 гаруй хүнийг доктор дэд эрдэмтний зэрэг хамгаалуулжээ.

М. И. Сладковский Хүрээлэнгийнхээ эрдэм шинжилгээний үйл ажлыг улам боловсронгуй болгох талаар цаг үргэлж анхаарч орчин үеийн хятадын үзэл суртал, гадаад бодлого, түүх, эдийн засгийн асуудлаар олон тооны ганц сэдэвт зохиол бүтээл туурвижээ. Үүнд: «Хятадын эдийн засгийн гадаад харилцааны товч түүх», М., 1953, «ЗСБНХ-Хятадын эдийн засгийн харилцааны товч түүх», М., 1957, «Хятад ба Япон» М., 1971, «Орос-хятадын ард түмний худалдаа эдийн засгийн харилцааны түүх (1917он хуртэл)», М.,1974,«ЗСБНХУ-Хятадын худалдаа эдийн засгийн харилцааны түүх (1917-1974)» М., «Хятад: үзэл суртал, эдийн засаг, түүхийн үндсэн асуудал», М.. 1978, «Хятад ба Англи», М.,1980 зэргийг дурдаж болно. Үүнээс гадна М. И. Сладковский ганц сэдэвт зохиол, олон

тооны өгүүлэл бичиж нийтлүүлжээ. М. И. Сладковский ЗСБНХУ болон гадаадад нэр хүндтэй хятад судлагч болж олонхи бүтээл нь гадаадад, түүний дотор манай оронд орчуулагдан хэвлэгдэв.

М. И. Сладковскийн судалгааны бүтээл нь өөрийн орны төдийгүй дэлхий дахины хятад судлалын хөгжилд чухал хувь нэмэр хандив болж байна. М. И. Сладковскийн гавъяа зүтгэл хөдөлмөрийн амжилтыг үнэлж Зөвлөлт засгийн газраас Лениний одонгоор 2 удаа, Октябрийн болон бусад олон одон медалиар шагнажээ.

М. И. Сладковский шинжлэх ухааны үйлсэд 40 жил зүтгэхдээ дэлхийд БНХАУ-ын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, орчин үеийн хятадын нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжлийн онцлог шинжийг судалж шийдвэрлэсэн нь түүний эрдэм шинжилгээний ажлын гол үр дүн байв. Тэр нь зохиол бүтээлдээ Хятад оронд шинжлэх ухааны социализмын үзэл санаа ялан мандах бодит зүй тогтлыг ул үндэстэй нотлон харуулснаас гадна Дорно дахины улс түмэнд ленинизм асар их үүрэг гүйцэтгэснийг Хятадын тодорхой жишээгээр үзүүлжээ. Түүний бүтээл нь хятадын ард түмний жинхэнэ эрх ашгийн төлөө хятадыг социалист хөгжлийн замд эргүүлж оруулах тэмцэлд нэмэр хандив болоод зогсохгүй марксизм-ленинизмд дайсагнасан ХКН дахь жижиг хөрөнгөтний бодлогыг шийдвэртэй няцаасанд оршино.

М. И. Сладковский Европын хятад судлалын холбооны хүндэт гишүүн, Ази, Африкийн орнуудын эв санааны нэгдлийн Зөв-

лөлтийн Хорооны орлогч дарга, «Проблемы Дальнего Востока» сэтгүүлийн ерөнхий редактор, ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын Хүрээлэнгийн дэргэдэх Эрдмийн зэрэг хамгаалах мэргэжлийн зөвлөлийн дарга, Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн дарга, Алс Дорнодын гадаад орнуудын асуудлаархи ЗСБНХУ-ын ШУА-ийн зөвлөлийн дарга юм. Түүнээс гадна бас шинжлэх ухааны олон нийгэмлэг зөвлөлийн гишүүн юм. Тэрээр Зөвлөлтийн болон гадаадын сонсогчдын өмнө тогтмол илтгэл лекц уншдаг бөгөөд БНМАУ-д хэд хэдэн удаа ирж орчин үеийн хятадын асуудлаар зохиосон эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумд идэвхтэй оролцож, манай орон дахь хятад судлалын ажлыг цаашид өрнүүлэхэд үнэт хувь нэмэр оруулж БНМАУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалыг үүсч байгуулагдахаас эхлээд Хүрээлэн болж өргөжих хүртэл маш идэвхтэй дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирэв. Хоёр орны найрамдлыг бэхжүүлэхэд М. И. Сладковскийн оруулсан хувь нэмрийг үнэлж БНМАУ-ын засгийн газар түүнийг «Алтан гадас» одонгоор хоёр удаа шагнажээ.

М. И. Сладковскийг мэргэжил нэгт монгол нөхөд пролетарийн интернационализмд чин үнэнч ахмад коммунист бидний дотнын анд нөхөр гэж гүнээ хүндэтгэдэг юм.

ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, нэрт эрдэмтэн М. И. Сладковскийн 75 насны ойг тохиолдуулан монголын нийт эрдэмтэд аз жаргал, эрүүл энх, урт удаан насалж эрдмийн ажилдаа улам өндөр бүтээл гаргах өлзийтэй ерөөлийг түүнд өргөн дэвшүүлж байна.